

МУИС-ийн Геологийн салбар — 65 жилд

Х.Уламбадрах, Б.Эрдэнэцогт

Монгол Улсын Их Сургууль, Геологийн салбар

Хураангуй

Монгол улсад 20-р зууны хагасаас эхлэн геологи шинжилгээний ажил эрчимтэй өрнөж эхэлснээр өсөн нэмэгдэж байгаа мэргэжилтний хэрэгцээг дотоодын боловсон хүчнээр хангах шаардлага гарч ирсэн бөгөөд үндэсний геологийн сургалтыг зохион байгуулсан нь Монголын геологийн салбарын хөгжилд томоохон түлхэц болсон байна.

1960 оны 4-р сарын 11-ний өдрийн БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн ба МАХН-ын Төв хорооны 171/112-р тогтоолоор МУИС-ийн БУФ-ийн 13 оюутныг Геологийн 3-р анги болгон, шинээр 39 оюутан элсүүлэн хичээллүүлж эхэлснээр Монгол улсад Геологийн дээд мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэж эхэлсэн түүхтэй. 1969 онд МУИС-ийн харьяанд Политехникийн Дээд Сургууль (ПДС) байгуулагдсанаар Геологийн салбар Геологи, Уул Уурхайн Факультет (ГУУФ) болон өргөжсөн ба 1982 онд ПДС нь МУИС-иас бие даан салсанаар МУИС-д Геологийн мэргэжилтэн бэлтгэх ажил зогссон байдаг.

Монгол улсын ууган их сургууль МУИС-д Геологийн анги зайлшгүй байх шаардлагаар 1991 онд МУИС-ийн Ректорын тушаал гарч, тухайн оны 4-р сарын 1-нд БУФ-ийн дэргэд Геологийн тэнхим байгуулагдаж Газарзүйн салбарын II дамжаанаас 6 оюутан шилжүүлэн сургалтын ажлыг эхлүүлснээр МУИС-д геологийн мэргэжилтэн бэлтгэх хоёр дахь үе шат эхэлсэн юм. 1992 оноос Геологийн салбарын багшлах боловсон хүчин, сургалт-эрдэм шинжилгээний үйл ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх зорилгоор өргөн мэдлэг боловсрол, үйлдвэрлэлийн дадлага туршлагатай эрдэмтэд, судлаачдыг багшаар ажиллуулж эхэлснээс хойш одоо тус тэнхим нь 13 багш, 2 туслах ажилтантайгаар ажиллаж байна. Тэнхимийн багш нар Монголын геологи, геодинамик, тектоник, ашигт малтмалын геологи, петрографийн судалгаа, палеогеограф, ашигт малтмалын ордын эдийн засгийн үнэлгээ, мөн зайнаас тандан судлал, газрын доорх усны экологи, нүүрсний геологи, шатах ашигт малтмалын геохимийн чиглэлүүдээр ажиллаж, олон арван бүтээл туурвижээ.

МУИС-иар “овоглогдох” нийт 1950-иад геологич байгаагийн 482 нь 1963-1982 онд төгссөн бол үлдсэн 1470 орчим геологич мэргэжилтнийг 1991 оноос хойш төгсгөжээ.

1. Оршил

Монгол улсад 20-р зууны хагасаас эхлэн геологи шинжилгээний ажил эрчимтэй өрнөж, нүүрс, газрын тос, алт, зэс, вольфрам, хайлуур жонш зэрэг төрөл бүрийн ашигт малтмалын ордуудыг шинээр нээн илрүүлж, уул уурхайн үйлдвэрүүд шинээр байгуулагдаж эхэлснээр өсөн нэмэгдэж байгаа мэргэжилтний хэрэгцээг дотоодын боловсон хүчнээр хангах шаардлага гарч ирсэн бөгөөд үндэсний геологийн сургалтыг зохион байгуулсан нь Монголын геологийн салбарын хөгжилд томоохон түлхэц болсон байна.

Геологийн чиглэлээр хэд хэдэн газарт үндэсний мэргэжилтнүүд бэлдэж байгаа боловч сургалтын гол үйл ажиллагаа МУИС, ШУТИС-д төвлөрч байна. Технологи эрчтэй хөгжиж байгаа өнөө үед орчин үеийн техник технологи ашиглах болон өндөр нарийвчлалтай лабораторид ажиллах чадвартай, онолын өндөр мэдлэгтэй мэргэжилтэнг бэлтгэх нь нэн тэргүүний эрхэм зорилго болж байна.

МУИС-ийн Геологийн салбар нь одоогоор 13 багш, 2 туслах ажилтантайгаар сургалтын үйл ажиллагаа явуулж байгаа ба геологийн

чиглэлээр бакалавр, магистр, докторын шаталсан сургалтаар мэргэжилтэн бэлтгэж байна.

Монгол улсад Геологийн мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэж эхэлсний 65 жилийн ой тохиож байгаа энэ өдрүүдэд 1991 онд МУИС-д Геологийн тэнхим дахин байгуулагдсан

болон үндэсний геологич мэргэжилтэн бэлтгэж эхэлсний 60 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлснээс хойших сүүлийн 5 жилийн сургалт, эрдэм шинжилгээний ажлын түүхэн хөгжлийг доор оруулав.

2. МУИС-ийн Геологийн салбарын түүхэн хөгжил, өнөөгийн байдал

1960 оны 4-р сарын 11-ний өдрийн БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн ба МАХН-ын Төв хорооны 171/112-р тогтоолын 3-р зүйлийн а хэсэгт “Улсын геологийн ажлыг үндэсний мэргэжлийн боловсон хүчнээр хангах зорилгоор Чойбалсангийн нэрэмжит Улсын Их Сургуулийн Газар зүйн салбарын 1,2-р ангийг түшиглүүлэн, 1960-1961 оны хичээлийн жилээс Геологийн салбар байгуулан хичээллүүлэхийг Шинжлэх ухаан, дээд боловсролын хүрээлэн /н.Б.Лхамсүрэн/-д даалгасугай.” гэж заасны дагуу тухайн ондоо МУИС-ийн БУФ-ийн Газар зүйн 3-р ангиас 13 оюутныг Геологийн 3-р анги болгон авч, шинээр 39 оюутан элсүүлэн хичээллүүлж эхэлснээр Монгол улсад Геологийн дээд мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэж эхэлжээ. Анхны багшаар тухайн үеийн СнЗ-ийн дэргэдэх Геологи шинжилгээний газрын ахлах геологич Ж.Дүгэрсүрэн ажилласан ба 1961 оны эхээр Геологи шинжилгээний газрын геологич Р.Барсболд, Ж.Лхамсүрэн нарыг үндсэн багшаар авч, мөн ЗХУ-аас уригдан ирсэн Петербург хотын Уул уурхайн институтын доцент, дэд эрдэмтэн К.М.Малкова, Львов хотын Их Сургуулийн доцент, дэд эрдэмтэн Ю.Ф.Пекун нар ажилласнаар Геологийн тэнхим (эрхлэгч Ж.Дүгэрсүрэн) байгуулагдаж биеэ даасан салбар болон хөгжжээ.

1969 оны 7-р сарын 17-ны БНМАУ-ын СнЗ-ийн 247 тоот тогтоолоор МУИС-ийн харьяанд Политехникийн Дээд Сургууль (ПДС)

байгуулагдсанаар Геологийн салбар Геологи, Уул Уурхайн Факультет (ГУУФ) болон өргөжиж МУИС-ийн харьяанд 1982 он хүртэл байсан юм. Энэ хооронд ГУУФ-д 1972 онд Уул уурхайн тэнхим, 1975 онд Гидрогеологийн тэнхим, 1980 онд Геодезийн тэнхимүүдийг шинээр байгуулж байжээ.

1982 оны 7-р сарын 21-ний МАХН-ын Төв Хорооны 227-р тогтоолоор ПДС нь МУИС-иас бие даан салсанаар МУИС-д Геологийн мэргэжилтэн бэлтгэх үйл ажиллагаа зогссон байдаг.

Монгол улсын ууган их сургууль МУИС-ийн Байгалийн ухааны салбарт Геологийн салбар зайлшгүй байх шаардлагаар МУИС-ийн Ректорын 1991 оны 4-р сарын 9-ний “Геологийн тэнхим нээн ажиллуулж, багш шилжүүлэх тухай” 266 тоот тушаал гарч, тухайн оны 4-р сарын 1-нд БУФ-ийн дэргэд Геологийн тэнхим байгуулагдсанаар МУИС-д геологийн мэргэжилтэн бэлтгэх хоёр дахь үе шат эхэлсэн юм. Техникийн Их Сургуулийн Геологи-минералогийн тэнхимээс проф. С.Дашдаваа, дэд проф. Я.Болд, хичээлийн туслах ажилтан М.Цагаанхүү нар томилогдон ирж шинэ салбарын сургалтын үйл ажиллагааг МУИС-ийн БУФ-ийн Газарзүйн салбарын II дамжаанаас 6 оюутан шилжүүлэн эхлүүлж байжээ. Геологийн тэнхимийн багшлах бүрэлдхүүнийг өргөжүүлснээр Төрийн шагналт, ш.у-ы доктор, профессор Ж.Бямба, ш.у-ы доктор, профессор Дэ.Бат-Эрдэнэ, доктор,

профессор Л.Жаргал, доктор, дэд профессор А.Пэрлээ, доктор, дэд профессор Д.Доржготов, доктор С.Авирмэд, доктор Б.Дэлгэрцогт, ахлах багш Н.Мөнхбилэг, З.Ганбаатар, багш Д.Оюунцэцэг, С.Хүрэлбаатар, В.Доржмаа нар тус тэнхимд багшиж байлаа. Төгсөгчдөөс 1997 оны төгсөгч Н.Байгалмаа, Н.Одгэрэл, С.Оюунгэрэл, 1998 оны төгсөгч Б.Эрдэнэцогт, 2000 оны төгсөгч Х.Уламбадрах, 2001 оны төгсөгч Д.Нансалмаа, 2005 оны төгсөгч Л.Оюунжаргал, 2008 оны төгсөгч Б.Тамир нар багшиж байна.

МУИС-ийн Геологийн салбар 1997-2013 онд Газарзүй-Геологийн Сургуульд, 2013 оноос Шинжлэх Ухааны Сургуулийн Байгалийн Ухааны Салбарт харьяалагдан геофизикийн салбартай нэгдэж Геологи, геофизикийн тэнхим болон зохион байгуулагдан ажиллаж байна.

Геологийн тэнхимийн эрхлэгчээр С.Дашдаваа (1991-2001, 2004-2005), Л.Жаргал (2001-2004, 2005-2007), Д.Доржготов (2007-2009), Х.Уламбадрах (2009-2010), Б.Бат (2010-2018), Ц.Баатарчулуун (2018-2019, 2022-2024), Б.Эрдэнэцогт (2020-2022), Б.Тамир (2019-2020, 2024 оноос) нар ажиллаж ирлээ.

2020 онд Монгол Улсад геологийн мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэж эхэлсний 60 жилийн ойг амжилттай тэмдэглэн өнгөрүүлснээс хойш МУИС-ийн Геологи, геофизикийн тэнхимийн хамт олон эрдэм шинжилгээ, сургалт, үйлдвэрлэлийн чиглэлээр амжилттай ажиллаж 65 жилийн ойтойгоо золгож байна.

Дээд боловсролын сургалтын байгууллага сургалт явуулж байгаа хөтөлбөрөөр дотоодын болон гадаадын магадлан итгэмжлэлд орох нь томоохон шалгуур болдог. Геологи, геофизикийн хөтөлбөрүүд 2024, 2022 онуудад БМИҮЗ-ийн магадлан итгэмжлэлийн шаардлагыг хангаж сургалт явуулах эрхээ 5 жилээр сунгуулсан нь тэнхимийн сургалтын үйл ажиллагаа үнэлэгдсэн

явдал юм.

МУИС-д геологич мэргэжилтэн бэлтгэж байгаа сургалтын үйл ажиллагаа шаталсан сургалттай болж бүрэн төлөвшсөн бөгөөд бүх шатны сургалтын төлөвлөгөөнд өөрчлөлт оруулсныг тэмдэглэх нь зүйтэй. 2025 оноос МУИС-ийн сургалтын төлөвлөгөөны өөрчлөлтөөр “Геологийн үндэс” хичээлийг МУИС-ийн суурь хичээл болгон оруулсан нь мэргэжлийн бус оюутнуудад геологийн мэргэжлийг таниулах, соён гэгээрүүлэх, мэргэжил сурталчлах, чухал алхам болж байна.

2024 онд багш Н.Байгалмаа, Н.Одгэрэл нар докторын зэрэг хамгаалснаар тэнхимийн эрдмийн зэрэгтэй багш нар 69.2% болж өслөө.

Эрдэм шинжилгээний ажлыг шинэ шатанд гаргах зорилгоор МУИС-ийн стратеги төлөвлөгөөтэй уялдуулан Геологи, эрдэс баялгийн судалгааны төвийг 2023 онд дахин байгуулан ажиллаж байна. Төвийн шугамаар Японы NHK телевизийн Great Nature цувралыг Монгол Улсад зохион байгуулахад оролцож, Х.Уламбадрах эрдэм шинжилгээний зөвлөхөөр ажилласан ба уг нэвтрүүлэг Япон улсад нэг өдрийн дотор 2.1 сая хүн үзсэнээр нэвтрүүлгийн түүхэнд 2-рт орох амжилтыг үзүүлсэн билээ.

Профессор Х.Уламбадрах Монголын геологи, тектоник, геоморфологийн чиглэлээр “Earth-Science Reviews”, “Gondwana Research”, “Ore Geology Reviews”, “Geomorphology”, “Frontiers in Earth Science” зэрэг дэлхийн нэр хүндтэй сэтгүүлүүдэд 1-р болон холбоо барих зохиогчоор бүтээлүүдээ хэвлүүлсэн бол профессор Б.Эрдэнэцогт Монголын шатах ашигт малтмал, нүүрсний геологийн судалгааны үр дүнгээ тэргүүлэх сэтгүүл болох “Marine and Petroleum Geology”-д 1-р зохиогчоор, дэд профессор С.Оюунгэрэл нэр хүнд бүхий “Episodes”,

“Geosciences Journal” сэтгүүлд 1-р болон холбоо барих зохиогчоор өгүүлэл хэвлүүлээд байна.

Тэнхимийн багш нар 2 жил тутам болдог “Монголын ба бүс нутгийн геологийн асуудлууд (GIMAR)” олон улсын хурал, “Монгол орны гүний тогтоцны судалгаа” зэрэг эрдэм шинжилгээний хурлуудыг амжилттай зохион байгуулан оролцож ирсэнээс гадна профессор Б.Эрдэнэцогт Олон улсын Органик петрологийн холбооны 40-р чуулганыг 2024 онд Монгол Улсад анх удаа амжилттай зохион байгуулж, ажлын хэсгийн ахлагчаар ажилласан нь Монгол орны шатах ашигт малтмалын геологийн судалгааны түвшинг дэлхийд таниулсан томоохон үр дүнтэй ажил болсон юм. Мөн тэнхимийн багш нараас Олон Улсын Геологийн Конгресс, Геологийн Улсын зөвлөгөөн, Mining Week, МУИС-80, Геологи-85 зэрэг олон улсын болон улсын хэмжээний томоохон хурлуудад илтгэгчээр тогтмол оролцож ирсэн билээ.

“Геологийн асуудлууд” эрдэм шинжилгээний сэтгүүл тогтмол гарч судлаачдын судалгааны үр дүнг хяналттай нийтэлж байгаа нь сэтгүүлийн чансааг өргөж, геологичдын уншдаг, мэргэжилдээ ашигладаг хэвлэл болж хэдийнэ чадсан байна.

Тэнхимийн багш нар гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэн БНСУ, БНХАУ, АНУ, Япон, ОХУ зэрэг олон улсын ижил төстэй байгууллага, эрдэмтэдтэй амжилттай хамтран ажиллаж байна. Дэд профессор С.Оюунгэрэлийн БНСУ-ын эрдэмтэдтэй хамтарсан олон жилийн тогтвортой хамтын ажиллагаа нь сургууль хоорондын төдийгүй Монголын геологийн судалгааны ахицад ихээхэн хувь нэмэр оруулсаар байгаа юм.

Профессор Я.Болдын нэрэмжит Ерөнхий геологийн улсын олимпиадыг жил бүр тогтмол зохион байгуулж ирлээ. Улмаар олон

улсын өсвөрийн геологичдын ба олон улсын геологийн олимпиадыг Монгол Улс, ОХУ-д зохион байгуулахад доктор, дэд профессор Б.Бат оролцож, Монгол Улсын багийн ахлагчаар амжилттай ажилласан байна.

Багш нараас ш.у-ны доктор Ж.Бямба ОХУ-ын Байгалийн шинжлэх ухааны академийн академич, Монгол Улсын төрийн шагнал хүртсэн бол доктор С.Дашдаваа, ш.у-ны доктор Дэ.Бат-Эрдэнэ, доктор Л.Жаргал нар МУИС-ийн профессор; доктор Я.Болд, А.Пэрлээ, Д.Доржготов, Б.Эрдэнэцогт нар МУИС-ийн дэд профессор цол хүртсэн.

МУИС-иар “овоглогдох” нийт 1950-иад геологич байдгийн 482 нь 1963-1982 онд төгссөн бол үлдсэн 1470 гаруй геологич мэргэжилтнийг 1991 оноос хойш төгсгөжээ.

Аж үйлдвэрийн гавьяат ажилтан геологич Д.Тогтох, Л.Мөнхтоогоо, Д.Гарамжав, Ж.Сумъяа, Г.Дэжидмаа, С.Должин, Ш.Лхүндэв, Б.Дэлгэрцогт, төрийн шагналт геологич С.Цэрэн-Очир, В.Довжид, Д.Гунгааням, С.Алтангэрэл, гавъяат багш Д.Чулуун, төрийн шагналт, СГЗ, зохиолч Д.Батбаяр, гавъяат тамирчин, шатрын олон улсын хэмжээний мастер Л.Мягмарсүрэн, гавъяат хуульч Д.Чилхаажав, соёлын гавъяат зүтгэлтэн Д.Машлай, Х.Пүрэвээ болон С.Дашдаваа, Ц.Цэдэн, Ч.Ээбум, Я.Болд, Ж.Ган-Очир, Ж.Бадамгарав, Д.Товуудорж, Л.Шархүү, Т.Семейхан, А.Пэрлээ, Н.Лхагва, Д.Чулуун, Ш.Батжаргал, Г.Ээнжин, Г.Дэжидмаа, С.Дандар, Д.Даваасамбуу, Г.Бадарч, Д.Доржготов, Б.Дэлгэрцогт, Д.Эрдэнэ, Л.Жаргал, Д.Бат-Өлзий зэрэг эрдэмтэн геологичид, мөн зураглалын Д.Санжаадорж, Х.Далихан, Ч.Цэдэнбал, Д.Чулуунбат, Ц.Баатар, И.Ниндэвгомбо, Ө.Жамъяндорж, А.Баатархуяг, Ц.Махбадар, Б.Энхбаяр зэрэг, ашигт малтмалын эрэл, хайгуулын судалгаанд үнэт хувь нэмэр

оруулсан Д.Баадай, Э.Болд, Б.Алтан-Очир, Н.Ням, Д.Дашцэрэн, Б.Бэгзсүрэн, М.Дамдинбат, А.Чимэддорж, Д.Пүрэвдорж, Т.Намсрай, Д.Жанчив, Х.Сүхбаатар зэрэг, геологийн байгууллагыг удирдаж байсан С.Сономцэвээн, Ч.Хуажин, Г.Болд, А.Баасанжав, Я.Долгор, Б.Гүрлхаажав, Ш.Баасандорж, Б.Батжаргал, Т.Сэнгэдорж, Л.Базарсад, С.Энхцэг нарын олон арван геологичид МУИС-ийн бахархал билээ.

1994 онд Монгол улсад анх удаа Газрын тосны геологич мэргэжлээр Г.Ган-Отго, Г.Сандуйжав, Б.Баянжаргал, Ч.Эрдэнэ нарын 4 мэргэжилтэн бэлтгэгдэн гарсан. 1995 оноос Геологи, эрэл хайгуул болон Газрын тосны геологич мэргэжлээр нийт 5 төгсөгч, 1996 оноос эхлэн Геологи, эрэл хайгуул болон шатах ашигт малтмалын эрэл, хайгуулын мэргэжилтэй боловсон хүчнийг бэлтгэн гаргаснаас хойш тасралтгүй өнөөг хүртэл төгсөлт явагджээ.

Төгсөгчдөөс Б.Баатарцогт, Н.Байгалмаа, Н.Одгэрэл, С.Оюунгэрэл (1997), Б.Эрдэнэцогт (1998), Т.Оюунчимэг (1999), Х.Уламбадрах (2000), Г.Эрдэнэсайхан (2002), Д.Баттогтох (2003), Л.Оюунжаргал (2005), Б.Амаржаргал, Б.Тамир (2008) нар эрдмийн зэрэг хамгаалан их дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагуудад үргэлжлүүлэн ажиллаж байгаа бол Ч.Алтанзул, Т.Отгонбаяр, А.Одончимэг, Б.Энхбаяр, Б.Отгонжаргал, Б.Гантулга, Ч.Ганзүрх, Н.Ганбат, Д.Батням, Д.Эрдэнэчимэг, Г.Алтанхуяг, И.Цогхүү, Л.Бахдал, Б.Лхагважав, Г.Ганхуяг, Ч.Мөнхнасан, С.Хоролсүрэн, Г.Эрдэнэбаяр, Г.Будмэд, Б.Нармандах, Т.Говьдэлгэр, П.Өнөболд, Э.Батбаяр, О.Одонтуяа, Э.Батзориг, Б.Одхүү, Х.Төмөрбаатар, Б.Оюунбат, Г.Ишжанцан, Д.Өгөөдэй, Б.Батзаяа, Б.Төмөр-Арслан,

М.Ариунболд, Ж.Мөнхбат нарын зэрэг олон арван геологичид төрөл бүрийн ашигт малтмалын эрэл хайгуулын ажлыг хийж, нөөц бодож ашиглалтанд хүлээлгэн өгөх чухал шаардлагатай ажлуудад дотоодын болон гадаадын байгууллагуудад үр бүтээлтэй ажиллаж байна. Б.Амаржаргал, Л.Дагва-Очир, Б.Идэрбаяр, И.Халнуунаа нар IF бүхий олон улсын сэтгүүлд 1-р зохиогчоор өгүүлэл хэвлүүлээ. Түүнчлэн Геологийн төрийн байгууллагуудад МУИС-ийн төгсөгчид Н.Мөнхбилэг, Х.Санчигдорж, П.Хүрэлхүү, Б.Сүнжидмаа, А.Амаржаргал, Ц.Минжинсор, Б.Золбообаяр, Ү.Ганбаатар, Д.Оргил нарын зэрэг олон мэргэжилтэн ажиллаж байна. Урлаг, спортын салбарт амжилт гаргаж ирсэн МУИС-ийн Геологийн салбарын төгсөгчид ахмад геологичдын буухиа тасралгүй үргэлжилж байгааг өнөө үеийн залуусын шилдэг төлөөлөл болсон сагсан бөмбөгийн спортын мастер Н.Золжаргал, Б.Батжавхлан, улсын алдарт уяач Г.Батболд нарын амжилт харуулж байгаа билээ.

Монгол улсад геологийн мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэж эхэлсний 65 жилийн ойг тохиолдуулан МУИС-ийн Геологийн салбар байгуулагдсан өдрөөс эхлэн геологичдыг бэлтгэх ажилд гар бие оролцон ажиллаж байсан ахмад болон одоо ажиллаж байгаа нийт багш нар, МУИС-ийн нэрээр овоглон Монгол орны нутаг дэвсгэрийн иж бүрэн геологийн судалгаанд оролцож, бүх масштабын геологийн зураглалыг гардан гүйцэтгэж, ашигт малтмалын олон арван орд газрыг нээн илрүүлэн олборлолтонд шилжүүлж, улс орныхоо хөгжил дэвшил, бүтээн байгуулалтанд нэр хүндтэйгээр оролцсон, үргэлжлүүлэн оролцож байгаа нийт төгсөгч геологичиддоо баяр хүргэж, аз жаргал сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.